



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 119

Номгон

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3а, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заагдсан ангилал бүхий 75,578,051,86 төгрөгийн хөрөнгийг цогцолбороор нь орон нутгийн өмчөөс төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлээс хасаж, төрийн өмчид хүлээлгэн өгөхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/ нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117059

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын
07-ны өдрийн 119 дүгээр тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Хөрөнгийн төрөл	Нийт өртөг	Элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллагын нэр
1	Төрийн Аудитын газар	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10 215 003,86		10 215 003,86	Төрийн өмчид
2	Төрийн Аудитын газар	Урдчилж гарсан зардал	350 000,00		350 000,00	Төрийн өмчид
3	Төрийн Аудитын газар	Хангамжийн материал	7 736 148,00		7 736 148,00	Төрийн өмчид
4	Төрийн Аудитын газар	Барилга, байгууламж	2 923 200,00	1 502 200,18	1 420 999,82	Төрийн өмчид
5	Төрийн Аудитын газар	Авто тээврийн хэрэгсэл	32 400 000,00	13 362 499,80	19 037 500,20	Төрийн өмчид
6	Төрийн Аудитын газар	Машин, тоног төхөөрөмж	12 000 050,00	3 843 598,31	8 156 451,69	Төрийн өмчид
7	Төрийн Аудитын газар	Тавилга, эд хогшил	8 566 350,00	6 922 492,71	1 643 857,29	Төрийн өмчид
8	Төрийн Аудитын газар	Номын фонд	507 300,00		507 300,00	Төрийн өмчид
9	Төрийн Аудитын газар	Програм хангамж	880 000,00	458 333,50	421 666,50	Төрийн өмчид
	Нийт хөрөнгийн дүн		75 578 051,86	26 089 124,50	49 488 927,36	-
	Төрийн Аудитын газар	Дахин үнэлгээний зөрүү	4 989 800,00		4 989 800,00	Төрийн өмчид
	Төрийн Аудитын газар	Үр дүн	(7 787 787,94)		(7 787 787,94)	Төрийн өмчид
	Төрийн Аудитын газар	Засгийн газрын хувь оролцоо	52 286 915,30		52 286 915,30	Төрийн өмчид
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн		49 488 927,36		49 488 927,36	